



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/19

Булган

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIV/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Элсний нүүдлээс хамгаалах зурвас байгуулах /Рашаант сум, Элсэн тасархай 2 га/” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

- Г.Гантулга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

- С.Алтанзул

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

- М.Алтанцэцэг

Байгаль, орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Иргэний төлөөлөл:

- Х.Баясгалан

Булган сумын иргэн

Нарийн бичгийн дарга:

- Д.Ариунжаргал

Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо /Г.Гантулга/-д үүрэг болгосугай.



В.БАТЗОРИГ